“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК

# “ОФФИСЫН БАРИЛГЫН ЗАСВАР”-ЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендерийн нэр: Оффисын барилгын засвар

Тендерийн дугаар: УБЦТС/20240101031

2024 он

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ ........ 7
1. Тендерийн цар хүрээ ........ 7
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг ........ 7
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж ........ 7
4. Худалдан авах ажиллагааны цахим систем ........ 7
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ........ 7
6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага ........ 7
7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага ........ 8
Б.АГУУЛГА ........ 8
8. Тендер шалгаруулалтын баримт бичиг ........ 8
9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах ........ 9
10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт ........ 9
11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах ........ 9
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ ........ 9
12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл ........ 9
13. Тендерийн иж бүрдэл ........ 10
14. Тендерийн жишиг маягтууд ........ 10
15. Хувилбарт санал ........ 10
16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг ........ 11
17. Чадавхын болон туршлагын шаардлага ........ 11
18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ........ 11
19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ........ 12
20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг ........ 12
21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт ........ 12
22. Тендерийн валют ........ 13
23. Тендер хүчинтэй байх хугацаа ........ 13
24. Тендерийн баталгаа ........ 13
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ ........ 14
25. Тендер баталгаажуулах, илгээх ........ 14
26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа ........ 14
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ ........ 14

27. Тендерийн талаар тодруулга авах ... 14
28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх ... 14
29. Тендерийг үнэлэх ... 15
30. Арифметик алдааг залруулах ... 15
31. Давуу эрх олгох ... 15
32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ... 15
33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох ... 15
34. Тендерийг эрэмбэлэх ... 15
35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах ... 15
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ... 16
36. Мэдэгдэл хүргүүлэх ... 16
37. Гүйцэтгэлийн баталгаа ... 16
38. Урьдчилгаа төлбөр ... 16
39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах ... 16

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | |
|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "**ажил**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| **2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг** | 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| **3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж** | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| **4. Худалдан авах ажиллагааны цахим систем** | 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна. |
| **5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх** | 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |
| | 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, $20^1$, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |
| **6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага** | 6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно. |
| | 6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй. |

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

**7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага**

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

## Б.АГУУЛГА

**8. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3.Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер

бэлтгэнэ.

| | |
|---|---|
| **9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах** | 9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын тавaас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.<br>9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.<br>9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.<br>9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.<br>9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө. |
| **10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт** | 10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.<br>10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.<br>10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно. |
| **11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах** | 11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.<br>11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.<br>11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын тавaас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана. |

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

| | |
|---|---|
| **12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл** | 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.<br>12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно. |

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т заасны дагуу цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг

тендерийн хамт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

**17. Чадавхын болон туршлагын шаардлага**

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох**

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага

| | |
|---|---|
| **баримт** | хангасан байна. |
| | 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. |
| | 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй. |
| **19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт** | 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. |
| | 19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна. |
| **20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг** | 20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ. |
| | 20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ. |
| | 20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. |
| **21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт** | 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна. |
| | 21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх |

бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.

21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.

21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

**22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

**23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

**24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах

ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

**25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

**27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар

авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

**29. Тендерийг үнэлэх**

29.1. Хуулийн 11.4-т зааснаар захиалагч үнэлгээний үндсэн шалгуурыг сонгох бөгөөд өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол үнэлгээний үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29.2. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.3. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

**30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

**31. Давуу эрх олгох**

31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн бол хуулийн 8.4, 8.7-т зааснаар үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.

**32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

**33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**

33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.

33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

**34. Тендерийг эрэмбэлэх**

34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.

**35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**

35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног

төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан эсэхийг дахин магадална.

35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

## Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

**36. Шийдвэр хүргүүлэх**

36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

**37. Гүйцэтгэлийн баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

**38. Урьдчилгаа төлбөр**

38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.

38.3. Урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

38.4. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

**39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

39.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

39.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
|---|---|
| **ТШЗ 1.1** | Захиалагч: **Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын нэр: **Оффисын барилгын засвар** |
| **ТШЗ 1.1** | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: **УБЦТС/20240101031** |
| **ТШЗ 1.2** | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:<br>**Багц-2: Ашиглалт засварын зүүн төвийн барилга засварын ажил;**<br>**Багц-3: Баянгол ХҮТ-ийн конторын барилгын гадна тохижилт;**<br>**Багц-4: -Баянзүрх ХҮТ-ийн оффисын засвар,**<br>**-Баянзүрх ХҮТ-ийн хэрэглэгчид хүлээн авах хэсгийн засвар;**<br>**Багц-5: Зуунмод ХҮТ-ийн барилгын өргөтгөл засвар;**<br>**Багц-6:- Налайх Төвийн барилгын гадна засвар,**<br>**-Налайх Төвийн танхим хүлээн авах хэсгийн засвар;**<br>**Багц-7: -ӨХАЗТ-ийн монтёруудын ариун цэврийн өрөөнд засвар хийх,**<br>**-ӨХАЗТ-ийн оффисын одоо барилгыг давхарлаж, өргөтгөн засварлах;**<br>**Багц-8: Сүхбаатар ХҮТ-ийн танхимын засвар;**<br>**Багц-9: Хан-Уул ХҮТ-ийн барилгын засварын ажил;** |
| **ТШЗ 1.3** | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **"Үгүй"** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: **Өөрийн хөрөнгөөр** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: **1,329,002,823 (Нэг тэрбум гурван зуун хорин есөн сая хоёр мянга найман зуун хорин гурав) төгрөг.**<br>**Багц-2: 84,217,800 (Наян дөрвөн сая хоёр зуун арван долоон мянга найман зуу) төгрөг;**<br>**Багц-3: 45,000,000 (Дөчин таван сая) төгрөг;**<br>**Багц-4: 102,538,100 (Нэг зуун хоёр сая таван зуун гучин найман мянга нэг зуу) төгрөг;**<br>**- 35,200,000 (Гучин таван сая хоёр зуу) төгрөг**<br>**- 67,338,100 (Жаран долоон сая гурван зуун гучин найман мянга нэг зуу) төгрөг.**<br>**Багц-5: 200,000,000 (Хоёр зуун сая) төгрөг;**<br>**Багц-6: 84,000,000 (Наян дөрвөн сая) төгрөг;**<br>**- 30,000,000 (Гучин сая) төгрөг**<br>**- 54,000,000 (Тавин дөрвөн сая) төгрөг**<br>**Багц-7: 580,000,000 (Таван зуун наян сая) төгрөг;**<br>**- 30,000,000 (Гучин сая) төгрөг**<br>**- 550,000,000 (Таван зуун тавин сая) төгрөг**<br>**Багц-8: 35,000,000 (Гучин таван сая) төгрөг;**<br>**Багц-9: 120,000,000 (Нэг зуун хорин сая) төгрөг;** |
| **Б.АГУУЛГА** | |
| **ТШЗ 9.1** | Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: |

<table>
<tr><td></td><td>Хүлээн авагчийн нэр: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “УБЦТС” ТӨХК-ийн төв байр, 604 тоот Хангамж үйлчилгээний хэлтсийн хангамжийн алба<br><br>Утасны дугаар: 976-11-342420+157<br><br>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногоос багагүй байна. /Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна /<br><br>Цахим шуудангийн хаяг: www.ubedn.mn</td></tr>
<tr><td>ТШЗ 10.1</td><td>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”</td></tr>
<tr><td colspan="2">B. ТЕНДЕР БЭЛТГЭХ</td></tr>
<tr><td>ТШЗ 12.1</td><td>Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”</td></tr>
<tr><td>ТШЗ 15.1</td><td>Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”</td></tr>
<tr><td>ТШЗ 16.1.2</td><td>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардахгүй”</td></tr>
<tr><td>ТШЗ 18.1</td><td>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”<br><br>- Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 он тус бүрийн борлуулалтын орлогын хэмжээ нь тухайн төсөвт өртгийн 80%-иас багагүй байна.<br>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна.<br>- Тендер нээсэн өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн татварын өргүй байх<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт-цахимаар илгээх</td></tr>
<tr><td>ТШЗ 18.2</td><td>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:<br><br>- Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан ирүүлнэ.</td></tr>
<tr><td>ТШЗ 19.1</td><td>Техникийн чадавх болон туршлагын шаардлага:<br><br>1.Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”<br><br>
<table>
<tr><td>д/д</td><td>Мэргэжил</td><td>Ажлын туршлага</td><td>Ажиллах хүний тоо</td></tr>
<tr><td>1</td><td>Барилгын инженер /үндсэн ажилтан/</td><td>3–аас доошгүй жил</td><td>1</td></tr>
<tr><td>2</td><td>ХАБЭА-И /үндсэн болон гэрээт байж болно. (Жич: Барилгын</td><td>2-аас доошгүй жил</td><td>1</td></tr>
</table></td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | инженер нь хавсарсан байж болно.) | | |
| 3 | Инженер, туслах ажилтангууд гэрээт байж болно. | 1-ээс доошгүй жил | 5-аас доошгүй |

Гэрээт ажилтны гэрээг хавсаргана. Ажлыг гүйцэтгэх боловсон хүчний мэдээлэл, жагсаалтыг тусгай зөвшөөрлийн хүрээнд маягтын дагуу ирүүлнэ.
Дээрх бичиг баримтыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй бөгөөд үнэн зөвийг тендерт оролцогч бүрэн хариуцна.

Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг V-р бүлгийн Маягт 2-т заасны дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ.

2.Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардана”**

**Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудыг дээрх жагсаалтын дагуу санал болгоно (өөрийн болон түрээсээр байж болно).**

3.Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага:

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:

**Сүүлийн 2 жил буюу 2022, 2023 он тус бүрт тухайн төсөвт өртгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /Ижил төстэй ажилд барилга угсралт болон гадна, дотор засварын ажлыг тооцно./**

Гэрээ, акт, гэрээ дүгнэсэн протоколын хуулбар ирүүлэх шаардлагатай.

4.Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: **“Шаардана”**

1. Ажлын тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна.
2. Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган /ажил гүйцэтгэх хугацаа 30 хоног байна./ баталгаажуулж ирүүлэх ба заасан хугацаанд бүрэн дуусган, санхүүжилтийн хуваарийг төсөвт өртөгтэй уялдуулна.
3. Засварын ажлын баталгаат хугацаа 12 сар байна.
4. Компанийн танилцуулга.

**ТШЗ 19.2**

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:

- **2022, 2023 он тус бүрт ижил төрлийн барилга угсралтын ажил болон гадна, дотор засварын ажлыг хийж гүйцэтгэж байсан туршлагыг харуулсан жагсаалыг Маягт 4 маягтаар доорх заалтын дагуу ирүүлнэ. Үүнд:**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |

| | |
|---|---|
| | (empty table row) |

| | |
|---|---|
| | **Дээрх жагсаалтаар ирүүлсэн ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээллийг ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл буюу Маягт 6 маягтаар гаргаж ирүүлнэ.**<br>- Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр төвшинд тухайн ажлыг графикийн дагуу гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.<br>- Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх.<br>- Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, тендерийн баримт бичгийн маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.<br>- Шалгарсан тохиолдолд Олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ; |
| **ТШЗ 19.3** | Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: **“Шаардана”**<br>Тусгай зөвшөөрөл нь гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй байна. Тусгай зөвшөөрлийн хугацаа нь гэрээний хугацаанд хүчинтэй байх. Хэрэв тусгай зөвшөөрлийн хугацаа нь гэрээний хугацаанд дуусхаар бол тусгай зөвшөөрөлгүйд тооцно.<br>**/Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна /** |
| **ТШЗ 21.6** | Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: **Тохируулахгүй тогтмол байна** |
| **ТШЗ 24.1** | Тендерийн баталгааны дүн: **Батлагдсан төсөвт өртгийн 0,5 хувьтай тэнцэх дүнтэй байх.**<br>Баталгааг цахимаар ирүүлээгүй нь энэ тендерээс татгалзах үндэслэл болно.<br>Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: **<u>Тийм</u>**<br>**Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний үнийн дүнгийн 3%-тай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлнэ.** |
| **Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ** | |
| **ТШЗ 25.5** | Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:<br>............................... |
| **ТШЗ 26.1** | Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:<br>Огноо: **2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр**<br>Цаг: **10 цаг 00минут** |
| **ТШЗ 26.2** | Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.<br>Огноо: **2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр**<br>Цаг**: 10 цаг 10 минут** |

| | |
|---|---|
| | Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: **Улаанбаатар хот, ХанУул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, УБЦТС ТӨХК-ийн төв байр 604 тоот өрөө.** |
| **Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ** | |
| **ТШЗ 31.1** | Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг:<br>1. Давуу эрх тооцуулах тухай хүсэлт;<br>2. Давуу эрх тооцуулах нөхцөл хангаж буй талаар нотлох баримт ирүүлнэ. |
| **ТШЗ 32.1** | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: **"Үгүй"** |
| **Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ** | |
| **ТШЗ 37.1** | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: **Үгүй** |
| **Ё. БУСАД** | |
| **ТШЗ 38.1** | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: **"Үгүй"** |

## III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

**Багц-2: Ашиглалт засварын зүүн төвийн барилга засварын ажил**

### 1-Р ДАВХРЫН КОРИДОРИЙН АЖИЛ

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Замаскан тэгшилгээ хийх | М2 | 40.7 |
| 2 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 40.7 |
| 3 | 2Х40Вт Флорисцент чийдэнтэй таазанд тоноглох гэрэлтуулэгч IP-20 | Ширхэг | 2 |

### 2-Р ДАВХРЫН МОНТЁРУУДЫН ОРОО БОЛОН КОРИДОРИЙН АЖИЛ

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хаалгыг буулгах | М2 | 11.76 |
| 2 | Паркет шалыг задлаж буулгах | М2 | 102 |
| 3 | Бетоны дэвсгэр ïе /бэлтгэл/ хийх М100 | М3 | 5.6 |
| 4 | 20мм зузаан бетон тэгшилгээ хийх М250 | М2 | 102 |
| 5 | Керамик хавтанцар нааж шал хийх | М2 | 102 |
| 6 | 2.5квмм огтлолтой ПВ-660 зэс голтой утас угсрах | М | 100 |
| 7 | Уян хоолойг угсрах. д-16 мм | Метр | 100 |
| 8 | 2Х40Вт Флорисцент чийдэнтэй таазанд тоноглох гэрэлтуулэгч IP-20 | ширхэг | 23 |
| 9 | Модон хаалга угсрах | М2 | 11.76 |
| 10 | Замаскан тэгшилгээ хийх | М2 | 138 |
| 11 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 138 |

### 3-Р ДАВХРЫН КОРИДОРИЙН АЖИЛ

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хаалгыг буулгах | М2 | 1.68 |
| 2 | Модон хаалга угсрах | М2 | 1.68 |
| 3 | Замаскан тэгшилгээ хийх | М2 | 16.5 |
| 4 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 16.5 |
| 5 | 2Х40Вт Флорисцент чийдэнтэй таазанд тоноглох гэрэлтуулэгч IP-20 | ширхэг | 2 |

### 4-Р ДАВХРЫН КОРИДОРИ, АЦО-НИЙ АЖИЛ

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Хаалгыг буулгах | М2 | 18.48 |
| 2 | Вааран хавтанцараар хийсэн ханын өнгөлгөөг буулгах | М2 | 14 |
| 3 | Вааран хавтанцараар хийсэн шалны өнгөлгөөг /хавтанцарыг эргүүлж ашиглахгүйгээр/ буулгах | М2 | 36 |
| 4 | Модон хаалга угсрах | М2 | 18.48 |
| 5 | Замаскан тэгшилгээ хийх | М2 | 124.2 |
| 6 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 124.2 |
| 7 | Керамик хавтанцар нааж шал хийх | М2 | 14 |
| 8 | Хананд плита наах | М2 | 36 |
| 9 | Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх | М2 | 48 |
| 10 | 2Х40Вт Флорисцент чийдэнтэй таазанд тоноглох гэрэлтуулэгч IP-20 | ширхэг | 9 |

**5-Р ДАВХРЫН КОРИДОРИЙН АЖИЛ**

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хаалгыг буулгах | М2 | 7.77 |
| 2 | Модон хаалга угсрах | М2 | 7.77 |
| 3 | Замаскан тэгшилгээ хийх | М2 | 34 |
| 4 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 34 |
| 5 | 2Х40Вт Флорисцент чийдэнтэй таазанд тоноглох гэрэлтуулэгч IP-20 | ширхэг | 4 |

**ШАЛНЫ АЖИЛ**

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Керамик хавтанцар нааж шал хийх | М2 | 99 |

**ХААЛГА, ЦОНХНЫ ЗАСВАРЫН АЖИЛ**

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих | М2 | 49.74 |
| 2 | Цонхны хуванцар тавцан хийх | 1М2 | 32.4 |
| 3 | Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах | М2 | 136.68 |
| 4 | Вакум цонхны нугастай далбааг задалж буулгах | 1 хайрцаг | 78 |
| 5 | Металл вакум хаалганы хайрцаг буулгах | 1 хайрцаг | 8 |

**ШАТНЫ ХОНГИЛ**

| № | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх | М2 | 346 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Хана, таазанд замаскан тэгшилгээ хийх | М2 | 346 |
| 3 | Таазыг эмульс хийх | М2 | 130 |
| 4 | Хана эмульсэн будгаар 2 удаа будах | М2 | 216 |
| 5 | Шатны бариул болон хайс сайн чанартай будах | М2 | 58 |
| 6 | Явган хана хийх | М2 | 80 |
| 7 | Заслалын шат угсрах ба задлах | М2 | 36 |

**Багц-3: Баянгол ХҮТ-ийн конторын барилгын гадна тохижилт**

УБЦТС ТӨХК. БГХҮТ-ийн гадна тохижилтын ажлын тоо хэмжээ

| № | Гүйцэтгэх ажлын нэр | хэмжих нэгж | тоо хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| ***1.Барилгын гадна засвар*** | | | | |
| 1 | Барилгын хаяавч хийх | м | 69.00 | Барилгын хаяавч бүтэн хийх |
| 2 | Ажилчдын хаалганы дээвэр/саравч/ хийх | м2 | 2.86 | Борооны хаалт шинээр хийх |
| 3 | Гадна шатны хэсэг | м2 | 81.26 | Чулуун хавтангаар солих |
| ***2. Гадна талбайн засвар*** | | | | |
| 1 | Явган хүний зам засварлах | м2 | 41.46 | Хуучирч эвдэрсэн зам шинэчлэх |
| 2 | Автозамын бродур солих | м | 130.00 | Хуучирсан бродур солих |
| 3 | Автозамын хучилт хийх | м2 | 330.00 | Урд талбайн тэгшилгээ, хучилт хийх |
| 5 | Автозамын тэмдэг, тэмдэглэгээ хийх | ш | 3.00 | |

**Багц-4: -Баянзүрх ХҮТ-ийн оффисын засвар, Баянзүрх ХҮТ-ийн хэрэглэгчид хүлээн авах хэсгийн засвар**

**Хэрэглэгчдийг хүлээн авах танхимын засвараар хийгдэх ажил:**

1. Хэрэглэгчдийг хүлээн авах танхимын хана таазыг битүү аккустик хавтангаар бүрэх – (Гэрээний мэргэжилтэн 9.60х5.35=51.36м2, Танхимын ажилтан 5.85х11.0= 64.35м2) нийт 115.76м2
2. Уналттай таазыг уналтгүй болгох
3. Хэрэглэгч орох хаалганы (хойд хаалга) үүд хэсгийг стандартад нийцсэн хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэн орох боломжтой байдлаар сунгах, замыг уртасгах
4. Хэрэглэгч орох хэсгийн үүдэнд 3-4м урттай цас бороонoос хамгаалах саравч
5. Хэрэглэгчдийг хүлээн авах танхимын амралтын өрөөг засварлах
6. Таазанд суурилуулах агааржуулагч – 3 ширхэг
7. Хаалга солих – 3 ширхэг
8. Агаар чийгшүүлэгч тавих – 2 ширхэг
9. Урд хаалганы (хуучин) хэсгийг тоосго эсвэл блокоор өрөх

10. Гэрээний өрөөний өргөтгөл хийх

**Оффис дотор засвараар хийгдэх ажил:**

1. Хурлын заалыг бүрэн засварлах 11.58x5.95=68.9м2
2. 2-р давхрын өрөөнүүдийн шалыг солих (5.50x3.05)x4=66.6м2
3. 3-р давхарт таазны кондишн тавих – 1 ширхэг

**Багц-5: Зуунмод ХҮТ-ийн барилгын өргөтгөл засвар**

**УБЦТС ТӨХК-ИЙН ЗУУНМОД ТӨВ-ИЙН БАРИЛГЫН ИХ ЗАСВАР ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

| № | Нэр | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Үндэслэл | Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуулийн Оношилгоо, зураг төслийн судалгааны “Ре констракшн” төвийн 2022.05.06-ны өдөр гаргасан Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Зуунмод хэрэглэгчдэд үйлчлэх төвийн оффисын барилгад хийсэн оношилгоо, экспертизийн тайлан |
| 2 | Байршил, талбай | Төв аймаг Зуунмод сум 1-р баг УБЦТС ТӨХК-ийн Зуунмод төвийн конторын барилга |
| 3 | Зориулалт, хүчин чадал | Конторын барилга |
| 4 | Одоогийн байдал | Байрны зоорийн болон 1-р давхрын өрөөний гадна, дотор хана ус чийгээс болж замаск будаг нь ховхорсон. |
| 5 | Ажил гүйцэтгэх хугацаа | 45 хоног |
| 6 | Захиалагч | УБЦТС ТӨХК-ИЙН ЗУУНМОД ТӨВ |
| 7 | Ажлын үе шат | Ажлын төсөв гаргах |
| 8 | Хийгдэх ажил | - **Буулгах ажил:**<br>- 11.6 м2 тоосгон хана буулгах /12см зузаантай/<br>- Вакум хаалт буулгах /28,4м2/<br>- Үүдний шат таллаж буулгах /12м2/<br>- **Хучилт, шалны цутгалтын ажил:**<br>- 2.3 м3 төмөр бетон шат, шатны талбай /М200/<br>- 6 м3 гадна довжоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан пандус цутгах<br>- Зоорийн давхрын шалыг бетон зутгалт хийнэ.<br>- **Дотор заслын ажил /зорийн давхар, 1-р давхар /:**<br>- Бетоны дэвсгэр үе хийх шалны тэшгилгээ ба тусгаарлалт хийх 9,2 м3<br>- Паркетан шал хийх 313 м2<br>- Чулуун хавтан дэвсэж шал хийх 60м2<br>- Шатны талбайд чулуун хавтан двсэж шал хийх 16 м2<br>- Өнгөт материалаар шатны хайс, хөгжлийн бэрхшээлтэй иргэний пандус ба бариул хийх 0.8 тн<br>- Тоосгон хамар хана өрөх 12,2 м2<br>- Хана шавардах 24,4 м2<br>- Хуучин будагтай ханын гадаргууг хусаж цэвэрлэх 118 м2<br>- Замаск 2 үе татах, зүлгүүр, будах 326 м2<br>- Танхимын ханыг дуу тусгаарлагчтай акустик хавтангаар бүрэн бүрэх 75 м2<br>- Танхимын хананд Лого болон Байгууллагын нэрыг хийж байршуулах |

| | | |
|---|---|---|
| | | - Танхимын ажилчдийн хэрэглэгч хүлээж авах ширээг стандартын дагуу шинээр хийж, ажилчин хоорондын тусгаарлах хаалт хийх<br>- Танхимын гэрээний ханын тавиурыг засварлаж байршуулах<br>- Гипсэн тааз угсрах 232 м2<br>- Таазны хар замаск 232 м2<br>- Таазны цагаан замаск 232 м2<br>- Модон хаалга суулгах /2.1*0.9-2.1*0.8/ 8 ширхэг<br>- Төмөр хаалга /1.8*08/ 1 ширхэг<br>- Панелан раиотор угсрах 7 ширхэг<br>- Халаалтын хуванцар хоолой ф25мм –н 90 метр<br>- Бөмбөлгөн хаалт ф25-н 20 ширхэг<br>- Танхим, борлуулалтын өрөө, зоорын даврын цонхыг иж бүрэн солих-/1,2*2,15 - 6 ш, 0,85*1,1-4 ш /<br>- Цонх тус бүрийн хэмжээнд тохирсон оффис хөшиг 15 ширхэг<br>- **Агаар сэлгэлт**<br>- Агаар дамжуулах гөлмөн төмөр хоолой 150*100мм хэмжээтэй 55 м2<br>- Сараалж Р150 –н 12 ширхэг<br>- Сэнс RP50-30/25-4D 1 ширхэг<br>- Архивын өрөөний агаар сэлгэлт, чийгшилд стандартын дагуу хийх.<br>- **Дотор гэрэлтүүлгийн ажил**<br>- Гэрэлтүүлгийн хувиарлах самбар угсрах IP31-2ш<br>- Гарцын гэрэлтүүлэгч цагаан чийдэнтэй хана таазанд угсрах IP44 – 2ш<br>- Хананд тоноглох өөр дээрээ цэнэг хуримтлуууртай аваарын гэрэлтүүлэгч IP54 – 4ш<br>- Лед чийдэнтэй гэрэлтүүлэгчтэй угсрах 36ш<br>- Унтраалга угсрах 22ш<br>- Розетка угсрах 60ш<br>- Хана, хамар хана хучилтын ховил буюу нүхэнд утас татах 850м<br>- Угаалтуурын дээд хэсэгт 30*120 гэрэлтүүлэгчийг угсрах 2ш<br>- Гадна пасадны гэрэлтүүлэг 126 м<br>- **Телефон утасны ажил**<br>- Телефоны сокт өрөөний тоогоор<br>- Зэс дамжуулагчтай политилен тусгаарлагч утас 500 метр<br>- Олон хосын кабелийг хэрэглэгчтэй холбох телефоны хувиарлах хайрцаг ДР-10 1 ширхэг, ДР-20 1 ширхэг<br>- Олон хосын кабель 250 метр<br>- Дотуур холбооны төхөөрөмж /АТС/ 1 станц<br>- **Галын дохиоллын ажил**<br>- 10 чиглэл хянах галын дохиоллын хүлээн авах станц суурилуулах 1 станц<br>- Удирдлагын гар угсрах 1ш<br>- Утаа мэдрэх хэт улаан туяаны галын дохиоллын мэдээлэгчийг угсрах 12ш |

| | | |
|---|---|---|
| | | - Дулаан мэдрэх галын дохиоллын мэдээлэгчийг угсрах 1ш<br>- Гараар удирдах галын дохиоллын мэдээлэгч хэрэгслийг угсрах 4ш<br>- Галын дохиоллын нэгтгэх хайрцаг тавих 1ш<br>- Зэс дамжуулагчтай полисэтилэн бүрээстэй 4 судастай утас /галд тэсвэртэй/ 1000м<br>- Түгшүүрийн дохио буюу бага чадлын сирень угсрах 4ш<br>- Тэжээлийн блок суурилуулах 1ш<br>- **Компьютерын сүлжээний ажил, кабелийн телевиз**<br>  - Зэс дамжуулагчтай бүрхүүлтэй 8 судастай утас 400 м<br>  - Компьютерийн сүлжээний сокт 20 ширхэг<br>  - Switch 16 port 2 ширхэг<br>  - Router 1 ширхэг<br>  - Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж FDF 1 ширхэг<br>  - Коаксиаль кабель 5С 200 метр<br>  - Кабелтийн телевизийн сокт 2 ширхэг<br>- **Давхарын самбар угсрах**<br>  - Давхрын самбар 800*800*200мм 1 ширхэг<br>  - Хуванцар хоолойг угсрах ф50мм –н 16 метр<br>  - Пластмассан хоолойг хучилтанд ф16мм –н 200 метр<br>  - Гүйдэл хүчдэл баригч цахилгаан тэжээлийн шулуутгагч 1 ширхэг<br>  - Холбоо дохиоллын rack 1 ширхэг<br>- **Тохижилийн ажил**<br>  - Тохижилт хий талбайг тэгшлэх 240 м2<br>  - Явган замын хашлага 30 ш<br>  - Явган хүний замын суурийг элс, хайрганы хольцоор хийх 12 м3<br>  - Явган хүний 60 м2 замын хучилтийг шаргал өнгөтэй хавтангаар хийх.<br>  - Ангилан ялгах хогийн сав 1 ширхэг<br>  - 1 толгойтой 6 метрийн өндөртэй добуртай замын гэрэлтүүэг 4 ком<br>  - Мод шилжүүлж суулгах<br>  - Гадна пасадний өнгө сайжруулах, гэрэлтүүлгийг солих<br>  - Гадна хашаа хайсыг засварлах, зориулалтын будгаар будах |
| 9 | Төсөл гүйцэтгэхэд ашиглах норм дүрэм | - Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД – 30-01-04/<br>- Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12*20/<br>- Төсвийг estimator pro програмаар хийсэн байна.<br>- Бусад холбогдох норм, дүрэм, заавар, стандарт |
| 10 | Нэмэлт нөхцөл | |

**Багц-6:- Налайх Төвийн барилгын гадна засвар, Налайх Төвийн танхим хүлээн авах хэсгийн засвар.**

1.АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

## ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Хуучин эмульстэй ханын гадаргууг хусаж цэвэрлэх | м2 | 75 |
| 2 | Хана эмульсээр будах | м2 | 106 |
| 3 | Хуучин тааз задалж буулгах | 10м2 | 5.97 |
| 4 | Хєнгєн цагаан рамтай 60х60 хэмжээтэй дїїжин тааз хийх | м2 | 59.7 |
| 5 | 60х60 дүүжин таазны гэрэл тавих | ширхэг | 8 |
| 6 | Тааз эмульсээр будах | м2 | 60 |
| 7 | Ердийн нөхцөлд ажиллах давхар төмөр каркастай хоёр талаасаа давхар гипсэн өнгөлгөөтөй 1ш хаалганы нүхтэй хамар хана угсрах | м2 | 15.6 |
| 8 | Гипсэн хананд дотор хаалга угсрах | ш | 1 |
| 9 | Мдф хавтангаар гоёлын хана угсрах | м2 | 29.7 |
| 10 | Мдф гадаргууд хуулга наах | м2 | 29.7 |
| 11 | Логотой шилэн хана угсрах | м2 | 9 |
| 12 | Ширээ, сандал, шилэн нүүртэй шүүгээ байрлуулах | ком | 3 |
| 13 | Шинээр гаргаж буй єрєєнд ширээ, сандал, шилэн нүүртэй шүүгээ байрлуулах | ком | 1 |

## 2.АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

### ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 1 ДАВХРЫН ДОТОР ЗАСАЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Модон хаалга усрах | м2 | 4 |
| 2 | Хаалганд цоож суулгах | ш | 4 |
| 3 | Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих | м2 | 4 |

### ТҮГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2 ДАВХРЫН ДОТОР ЗАСАЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Модон хаалга усрах | м2 | 7 |
| 2 | Хаалганд цоож суулгах | ш | 7 |
| 3 | Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих | м2 | 7 |

### БАГАХАНГАЙ АЖЛЫН БАЙРНЫ 1 ДАВХРЫН ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Цонх солих | ш | 5 |
| 2 | Цонхны зай завсрыг баллонтой шїршдэг хөөсөөр чигжиж дулаалах | ш | 5 |
| 3 | Хана, таазанд замаск засал хийх | м2 | 64.8 |
| 4 | Хуучин будагтай хана, таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх | м2 | 64.8 |
| 5 | Шалны тэгшилгээ хийх | м2 | 55 |
| 6 | Хана, тааз шавардах | м2 | 64.8 |
| 7 | Хана, таазыг эмульсээр будах | м2 | 64.8 |
| 8 | Дулаалгатай паркетан шал, шалны хөвөө хийх | м2 | 55 |
| 9 | Цонхны тавцан шинэчлэх | м2 | 8 |
| 10 | Модон хаалга усрах 2ш | м2 | 4 |
| 11 | Хаалганд цоож суулгах | ш | 2 |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих | м2 | 4 |
| 13 | Ариун цэврийн өрөөний шалны плита солих | м2 | 12.8 |
| 14 | Суултуур байрлуулах | ш | 2 |
| 15 | Угаалтуур, холигч, сифоны хамт байрлуулах | ш | 1 |

БАГАХАНГАЙ АЖЛЫН БАЙРНЫ 2 ДАВХРЫН ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

| Д/Д | Ажлын нэр | Нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | 2 давхрын шат налуу болгож засварлах | м | 7 |
| 2 | Цонх солих | ш | 4 |
| 3 | Цонхны зай завсрыг баллонтой шїршдэг хєєсєєр чигжиж дулаалах | ш | 4 |
| 4 | Цонхны тавцан засах | м2 | 6 |

**Багц-7: -ӨХАЗТ-ийн монтёруудын ариун цэврийн өрөөнд засвар хийх, ӨХАЗТ-ийн оффисын одоо барилгыг давхарлаж, өргөтгөн засварлах.**

| № | ӨХАЗТ-ийн засвар хийх өрөө | Талбайн хэмжээ м2 | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Монтёрын өрөө | 44.5 | Халуун хүйтэн усны шугам хоолойг бүхэлд нь солих шаардлагатай |
| 2 | Халуун усны өрөө | 30.1 | |
| 3 | Ариун цэврийн өрөө | 21.7 | |

**“УБЦТС” ХК ӨНДӨР ХҮЧДЭЛ АШИГЛАЛТ, ЗАСВАРЫН ТӨВИЙН ӨРГӨТГӨЛИЙН БАРИЛГА /ДАВХАР НЭМЖ/ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР**

| | | |
|---|---|---|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVII.3.2. |
| 2 | Барилга байгууламжийн нэр,байршил: | УБ, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Үйлдвэрийн гудамж-1<br>“УБЦТС” ХХК Өндөр хүчдэл ашиглалт, засварын төвийн өргөтгөлийн барилга. |
| 3. | Хөрөнгийн эх үүсвэр : | Компанийн төсвийн хөрөнгө оруулалт. |
| 4. | Захиалагч байгууллага: | “УБЦТС” ХК Өндөр хүчдэл ашиглалт, засварын төв. |

<table>
<tr><td>5.</td><td>Архитектур төлөвлөлтийн объектын бүрэлдэхүүн шаардлага, хүчин чадал:</td><td>Зураг төслийг одоогоор мөрдөгдөж буй хууль, норм ба дүрэм, стандартуудыг баримтлан боловсруулах.<br><br>Давхар нэмж барихтай болбоотой талбайн архитектур төлөвлөлтөд тавигдах шаардлага.<br><br>Барилга нь тэнхлэгээрээ 12.4x21.0 м харьцаатай ба өндрийг хийц бүтээцэд нийцүүлэн захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөх.<br><br>Өрөөний төлөвлөлт<br><br><u>Гурав дугаар давхарт</u><br>1. Даргын туслахын өрөө 8.8 кв.м<br>2. Даргын арын өрөө 8.05 кв.м<br>3. Даргын өрөө 22.8 кв.м<br>4. Санхүү Ня.Бо ажилчдын өрөө 24.84 кв.м<br>5. Сургалтын заал 60.33 кв.м<br>6. ИТА-ийн өрөө 38.68 кв.м<br>7. Шуурхай А.Удирдлагын өрөө 16.38 кв.м<br>8. Ариун цэврийн өрөө Эр/Эм 8.78 кв.м<br>9. Коридор 12.5 кв.м<br>10. Хүлээлгийн хэсэг 22.0 кв.м<br>11. Шатны хонгил 16.13 кв.м<br>Одоо байгаа 2 давхар барилгын шатны хонгил болон ариун цэврийн өрөөтэй уялдуулан төлөвлөх.</td></tr>
<tr><td>6.</td><td>Барилгын үндсэн хийц</td><td><u>Давхар нэмэх хэсгийн үндсэн хийц</u><br>- Рам: Металл каркас<br>- Гадна хана: Дүүргэгч блок, эрдэс хөвөн дулаалга /тооцоогоор/ бүхий металл фасад.<br>- Дээвэр: Хоёр талын налуу уналттай сэндвич нь хавтан дуу чимээ тусгаарлагч үетэй<br>- Цонх: Хуванцар рам бүхий 3 давхар шилтэй вакум цонх.<br>- Дотор хана: тоосгон өрөгт хан, шилэн хан, гипсэн хан байна.<br>- Шал: Стандартын шаардлага хангасан өрөө тасалгааны зориулалтаар хамаарсан өнгө үзэмтэй материалаар хийх.<br>- Хаалга: Стандартын шаардлага хангасан цагаан өнгийн модон хаалга байна.</td></tr>
<tr><td>7.</td><td>Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага</td><td>Загвар зураг боловсруулж баталгаажуулсны дараа төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон одоо байгаа 2 давхар барилгын дотор шугам сүлжээнд нэмэгдэх ачааллыг тооцож хангагч байгууллагуудаас олгох техникийн нөхцөлийн хүрээнд зураг төслийг боловсруулан эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөн батлуулах. Үүнд:<br><br>Цахилгаан хангамж, Дулаан хангамж, Ус хангамж, Ариутгах татуурга, Холбоо дохиолол</td></tr>
<tr><td>8.</td><td>Зураг төслийн бүрдэл:</td><td><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u><br>- Газрын гэрчилгээ, кадастрын зураг<br>- Инженер геологийн дүгнэлт<br>- Техникийн нөхцөлүүд /УСУГ, УБДС, УБЦТС, МХС/<br>- Онцгой байдлын дүгнэлт<br>- Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт<br>- Магадлалын ерөнхий дүгнэлт /Хавсралтын хамт/<br>- Барилгын хувийн хэрэг болон бусад холбогдох бичиг баримт<br><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u><br>- Нүүр хуудас /Батлагдсан/</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | - Барилга архитектур /БА/<br>- Технологийн байгуулалт /ТХ/<br>- Барилга бүтээц /ББ/<br>- Цахилгаан хангамж/ЦХ/<br>- Холбоо дохиолол /ХД/<br>- Халаалт агаар сэлгэлт/ХАС/<br>- Цэвэр бохир ус /ЦБУ/<br>- Хүчит төхөөрөмж, Дотор гэрэлтүүлэг /ХТ,ДГ/<br>- Барилгын нэгдсэн төсөв /Тооцооны ESTIMATOR-PRO программ/<br>- Хэвлэмэл байдлаар 2% |
| 9. | Ажлын үе шат, хугацаа: | Зураг төсөв боловсруулах<br>- Талбайн судалгаа хийх.<br>- Эх загвар зураг боловсруулж батлуулах.<br>- Иж бүрэн ажлын зураг төсөв боловсруулж зөвшилцөж батлуулах.<br>Ажил гүйцэтгэх<br>- Батлагдсан иж бүрэн ажлын зураг төсвийн дагуу барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх.<br>Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 10. | Төсөл боловсруулах байгууллага: | Тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд. |
| 11.<br><br>12. | Онцгой нөхцөл:<br><br>Галын аюулгүй байдал: | - Батлагдсан загвар зургийг үндэслэн шугам сүлжээний ачаалал тооцож хангагч байгууллагуудаас техникийн нөхцөлүүдийг гаргуулан ажлын зураг, төсвийг иж бүрэн боловсруулна.<br>- Санал болгох үнийн дүнд шинээр хийгдэх зургийн үнэ болон барилга угсралт, зөөж шилжүүлэх, нөхөн сэргээх болон тухайн ажилтай холбоотой өртөг бүгд багтсан байна.<br>- Газар хөдлөлийн мужид хамаарах тухайн байршилд хийгдсэн инженер геологийг үндэслэнэ.<br>- Тус барилгын дотор засалд хэрэглэх материал нь хурц үнэргүй, эрүүл мэндэд хоргүй, норм дүрэм, стандарт, шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн байх.<br>- Дулааны хэмнэлттэй байх.<br>- Ашиглалтын зардал бага байх эрчим хүчинд хэмнэлттэй орчин үеийн шийдэл бүхий тоног төхөөрөмж төлөвлөх.<br>Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНбД 21-01-02, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНбД 21-02-02-ийн холбогдох шаардлагуудыг хангасан байх. |
| 13. | Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ: | - Estimator pro болон Төсөв-1программаар хийгдсэн байна.<br>- Загвар зураг төслийг одоогоор мөрдөгдөж буй барилгын норм дүрэм, стандартуудыг баримтлан захиалагчийн хүсэлтийн дагуу боловсруулан батлуулсны дараа ажлын зургийг гүйцэтгэн магадлалаар батлуулж, Барилгын ажлыг эхэлнэ. |

**Багц-8: Сүхбаатар ХҮТ-ийн танхимын засвар**

Сүхбаатар хэрэглэгчдэд үйлчлэх төвийн салбар танхимын барилга гадна фасад дээвэр дотор засалын ажил хийнэ.

| № | Засвар хийгдэх ажил | Тайлбар | Талбайн хэмжээ өргөн *урт* өндөр | м2 |
|---|---|---|---|---|
| 1. | Хана засварлах | Хана замаскадах /1 талын хананд дуу намсгагчтай хананы наалт хийх болон үлдсэн хэсэгт обойг солих/ | 18,8*4 | 75 м2 |
| 2. | Паркетан шал солих | Маш их эвдрэлтэй хөлд тээглэж шороо бужигнадаг мөөгөнцөртэй ховхорч пөмбийж овоосон хөндийрсэн | 8*8 | 64 м2 |
| 3. | Танхимын тааз засварлах | Засварлан шинэчлэх /хавтан унжсан дан нурууг сэргээн засварлана/ зарим газар ус нэвчсэн | 8*8 | 64 м2 |
| 4. | Салбар танхим үүдний гонх /тамбор/ шинээр солих | Дээвэр элэгдэж цоорсон, суурь хазайсан хаалга салсан /засварлах боломжгүй/ шал шинээр цутгаж бүтэн солих резинэн шал, дуу чимээ тусгаарлагч дэвсгэр хийх шаардлагатай | 3*4 | 12 м2 |
| 5. | Дээвэр засварлах | Гандаж өнгө үзэмж алдсан ус гоожиж элэгдсэн дулаалага шаардлага хангахгүй болсон, зэвэрсэн А нурууны мод дүүргэлтийн банз сольж засварлана | 9*10 | 90 м2 |
| 6. | Хаалга солих | Гадна 2ш /бүргэд хаалга/ дотор өрөө 2ш /модон хаалга/ | 4ш | 4,8 м2 |
| 7. | Ажилтан болон хэрэглэгчиийг тусгаарлах тек солих | Текний байршлыг сольж шинэчлэх олон дахин будаж өнгө үзэмжгүй болсон мөн хаалга нь эвдрэлтэй | 1ш | 17 м2 |
| 8. | Гадна шат хийх | Үүдний шат байхгүй ахмад настай болон хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчид үйлчлүүлэхэд хүндрэлтэй /довжо/ | 2 | 6 м2 |
| 9. | Ванкум цонх солих | Цонх солих /гажсан сийгдэг, цоож эвдэрсэн тул шинээр солих/ Цонхны тавцан солих | 1,5*1,2*3 | 5,4 м2 |
| 10. | Ганда пасат солих | Си төмрөөр рам зангидах чулуун хөвөн хийж дулаалах сайтангаар пасат хийнэ | 27*4 | 108 м2 |
| 11. | Монтаж сольно | Шинээр бүх монтаж сольно /разетка унтраалга гэрэл автомат Щит суурьлуулна / | 1 | 1 |

**Багц-9: Хан-Уул ХҮТ-ийн барилгын засварын ажил**

Барилгын ажлын техникийн тодорхойлолт нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл болох манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Барилгын норм , дүрэм” стандарт , техникийн нөхцөлийг иж бүрэн баримтална.

Тендерийн нарийвчилсан үнэлгээнд төсвийн тооцооны бодит байдал, ажлын үнэлгээний сонголт , ажлын хөдөлмөр зарцуулалтын дүн, түүний ажил гүйцэтгэх графиктай уялдсан байдал, зааснаас илүү, дутуу тооцсон эсэх зэргийг нарийвчлан хянаж дүгнэнэ.

Төсвийн тооцоонд цалин, материал, тээвэр, механизмын зардал, магадалашгүй ажил, нормчлолын сан, бусад шууд зардал, нэмэгдэл зардал, ашиг, захиалагчийн техник хяналтын зардал , нэмэгдсэн өртгийн татвар, зэргийг улсын хэмжээнд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрэм, заавар, тушаал шийдвэрийг үндэслэн зохионо.

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль, тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Бүх бараа материал нь шинэ, ашиглагдаагүй, олон улсын стандартад нийцсэн байна.

Барилгын ажлын чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

Засвараас гарсан хог хаягдлыг тухайн дүүргийн зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэж зайлуулахаар зардлыг тооцож үнийн саналаа ирүүлнэ.

Энэхүү баримт бичгийн Ажлын тоо хэмжээ гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Ажлыг гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч ажиллана.

Материалын сонголт өнгөний шийдлийг бодит загвараар нь үзүүлж захиалагчийн саналыг тусгана.

**Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:**

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график

Заслын ажилд ашиглагдах материал нь дараах шаардлагыг хангасан байна.

**Заслын материал:**

- Хүний эрүүл мэндэд хор нөлөөгүй , аюулгүй, эрүүл ахуйн шаардлагыг дээд зэргээр хангасан байна.

**Гэрэлтүүлэгч:**

- Заслын ажилд солигдох бүх төрлийн гэрэл нь хүчин чадал, хэлбэр, хэмжээ дизайны хувьд харилцан адилгүй тул захиалагчтай зөвшилцөн сонгоно.

**Хана:**

- Дотор заслын зориулалттай, гал дэмждэггүй, ус чийг тусгаарладаг, өрөө тусгаарлах, дуу чимээ тусгаарлах хүний биед хоргүй шалнаас тааз хүртэл бүрж хийнэ. Өнгийг захиалгатай зөвшилцөн сонгоно.

**Шал:**

- Хүний биед хоргүй, үнэргүй, нян бактери устгагчтай, 60х60 тай /плита болон дрож/ шал байна. Өнгийг захиалагчтай зөвшилцөн сонгоно.

**Хаалга:**

- Дотор хаалга нь бусад хаалгатай ижил өнгийн будагтай, дуу тусгаарлагчтай модон хаалга байх. Монгол улсад үйлдвэрлэгдэж байгаатай дүйцэхүйц чанартай байх.

  / 6 дугаар давхрын бүрэн цутгамал хана зүсэж нураан хаалга хийх /
- Шилэн хаалга нь өндөр чанарын нягтралтай, гэрлийг сайн нэвтрүүлэх. Чимээ гаргахгүй уян хатан хөдөлгөдөг нугастай байх.

  / 1 дүгээр давхрын шилэн хана хоорондын хаалга /

**Тааз:**

- Одоо байгаа таазыг буулгаж, гипсэн таазаар солино.

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Ажлын төсөвт өртгийг тооцохдоо ажлын тоо хэмжээний жагсаалтанд өгөгдсөн хэмжээгээр тооцох ба техникийн тодорхойлолтод заагдсанаар гүйцэтгэнэ.

Ажлын тоо хэмжээний жагсаалт

| Д/Д | Гүйцэтгэх ажлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| **1** | **Буулгалтын ажил** | | |
| 1.1 | Хуучин тааз буулгах | м2 | 118.94 |
| 1.2 | Хуучин хана буулгах | м2 | 125.06 |
| 1.3 | Хуучин шилэн хана буулгах | м2 | 53.63 |
| 1.4 | Хуучин шал буулгах | м2 | 118.94 |
| 1.5 | Хог цэвэрлэж зөөвөрлөх | | |
| **2** | **Заслын ажил** | | |
| 2.1 | Уналттай гипсэн тааз угсрах | м2 | 103.3 |
| 2.2 | Гипсэн хамар хана угсрах | м2 | 35.89 |
| 2.3 | Таазанд засал хийх | м2 | 103.3 |
| 2.4 | Мебель хавтан хана угсрах | м2 | 146.94 |
| 2.5 | Маталттай HPL өнгөлгөөтэй хавтан хан угсрах | м2 | 11.63 |
| 2.6 | Уян тааз угсрах | м2 | 3.75 |
| 2.7 | Шилэн хана, хаалганы хүчитгэл хийх | м2 | 6.25 |
| 2.8 | Шилэн хана, хаалга угсрах | м2 | 28.52 |
| 2.9 | Хаалганд нерж амалгаа угсрах | м2 | 4.8 |
| **3** | **Шалны ажил** | | |
| 3.1 | Шаланд дрож наах | м2 | 49.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 3.2 | Заалны шаланд плита наах | м2 | 69.11 |
| 3.3 | Ам дарагч хийх | у/м | 8.3 |
| 3.4 | Плинтус хийх | у/м | 51.1 |
| **4** | **Бусад ажил** | | |
| 4.1 | Гэрэлтүүлгийн ажил | м2 | 118.94 |
| 4.2 | Гэрэлтэй самбар угсрах | м2 | 7 |
| 4.3 | Хаяг лого | ш | 2 |
| **5** | **Нэмэлт ажил / 6-р давхар** | | |
| 5.1 | Хана зүсэж нурааж хаалга хийх | м2 | 2.16 |
| 5.2 | Шилэн хана суурилуулах | м2 | 9.2 |
| 5.2 | Хог цэвэрлэж зөөвөрлөх | | |

## V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

## Маягт 1. Тендер илгээх

**[огноо]**

**[Захиалагч байгууллагын нэр]**-д

Манай **[оролцогчийн нэр]** нь танай байгууллагаас зарласан **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад **[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “**тендер**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.

2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.

3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.

4. Тендерт үнийн хөнгөлөлт **[“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]**. **[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]**.

5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо]** өдрийн хугацаанд хүчинтэй байна.[1]

6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.

7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

---

[1] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “*5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасанаар хугацаагүй хүчинтэй байна.*” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

**[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,**

**эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,**

**албан тушаал, гарын үсэг,**

**байгууллагын тамга, тэмдэг]:**

**Хаяг:**

## Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

| Албан тушаал | Ажилтны нэр | Боловсрол, мэргэжлийн ур чадвар | Нийт ажлын туршлага, жилээр | Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

## Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

| Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт | Хүчин чадал | Тоо ширхэг | [“Өөрийн эзэмшил” эсхүл “түрээс” аль нэгийг бичих] |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

## Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

## Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

| |
|---|
| Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө]. |

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |

## Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

| | **Нууцалсан баримт бичиг, мэдээлэл** | **Нууцалсан хууль зүйн үндэслэл** |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;

1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;

1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;

1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ

Захиалагчийн нийтлэг үүрэг

2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.

2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.

2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.

Захиалагчийн төлөөлөгч

2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.

2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Талбайд нэвтрэх зөвшөөрөл

2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.

2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

**Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг**

3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.

3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.

3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.

3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.

3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.

**Гүйцэтгэгчийн төлөөлөгч**

3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.

3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

**Техникийн болон ажлын талбайн өгөгдөл**

3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.

**Ажлын талбайн харуул хамгаалалт**

3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.

3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.

Хог, хаягдал ба нөхөн сэргээлт

3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.

3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.

3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.

Археологийн болон бусад олдвор

3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.

Аюулгүй байдал

3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.

3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.

3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.

3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.

3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.

3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын

үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.

4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;

4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;

4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.

4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.

4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

Ажлын явцын тайлан

4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.

4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

## ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ

5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.

5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

Урьдчилгаа төлбөр

5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.

5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.

Төлбөрийн нөхцөл

5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.

5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.

5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

Урьдчилгаа төлбөрийн баталгаа

6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.

Чанарын баталгаа

6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.

6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.

6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.

6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Баталгаат хугацаа

6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.

6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

## ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

Бусдад учруулсан хохирлыг арилгах

7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.

Захиалагчийн хүлээх эрсдэл

7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;

7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;

7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;

7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.

7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

Даатгал

7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.

7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.

7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.

7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.

7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

## НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

Доголдлыг илрүүлэх, арилгах

8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.

8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.

8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.

8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.

8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.

8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

Далд доголдол

8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Зураг төслийн доголдол

8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.

8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

## ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

Захиалагч гэрээг цуцлах

9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:

9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;

9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;

9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;

9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;

9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;

9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.

9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.

9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.

Гүйцэтгэгч гэрээг цуцлах

9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:

9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;

9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.

Гэрээг цуцлах журам

9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.

9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.

Гэрээг цуцалсны дараах төлбөр

9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.

9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:

9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;

9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;

9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;

9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;

9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

## АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.

10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа,

баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

**Төлөөлөгч өөрчлөгдөх**

10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.

10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

**Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл**

10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.

10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

| | | |
|---|---|---|
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | 10.16. | Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно. |
| | 10.17. | Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. |
| | 10.18. | Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна. |
| | 10.19. | Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно. |
| Оюуны өмчийн эрх зөрчих | 10.20. | Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. |
| Алданги | 10.21. | Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө. |
| | 10.22. | Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. |
| | 10.23. | Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. |
| | 10.24. | Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө. |
| Маргаан шийдвэрлэх | 10.25. | Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. |
| | 10.26. | Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. |

# ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| ГЕН 4.1. | Ажил эхлэх хугацаа**:** ***Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоног*** |
| ГЕН 4.2. | Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: **[он, сар, өдөр]** |
| ГЕН 4.9. | Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: ***30 хоногийн хугацаанд*** |
| ГЕН 5.2. | Үнийн тохируулга**:** ***Тохируулахгүй тогтмол байна.*** |
| ГЕН 5.4. | Урьдчилгаа төлбөр олгох эсэх: **“Үгүй”**<br>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: **0** |
| ГЕН 5.5. | Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: **0** |
| ГЕН 5.6. | Төлбөр төлөх хугацаа: **Гүйцэтгэсэн ажлын гэрээний үнийн 95 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 90 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн төлнө.**<br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: **[он, сар, өдөр]** |
| ГЕН 6.1. | Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: 0 |
| ГЕН 6.7. | **Чанарын баталгаа:**<br><br>Чанарын баталгаа шаардах эсэх: ***Шаардана 12 сар***<br>Чанарын баталгааны хэмжээ: **Гэрээний үнийн дүнгийн 5% байна.** |
| ГЕН 6.13. | Баталгаат хугацаа: ***Баталгаат хугацаа 12 сар байна.*** |
| ГЕН 7.5. | Даатгал:<br>**Гүйцэтгэгч нь *бараа материал, ажилтай холбогдолтой бүхий л даатгалыг хариуцна.*** |
| ГЕН 10.21. | **Захиалагчийн төлөх алдангийн хувь:0** |
| ГЕН 10.22. | **Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:**<br><br>Алдангийн хувь**:** ***Хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0,2%***<br>Алдангийн нийт дүн: ***Гэрээний нийт дүнгийн 20%*** |

**ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ**

**[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]** гэрээ**.**
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.............................. хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
   3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
   3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
   3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
   3.7. Техникийн тодорхойлолт;
   3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
   Эцэг/эх-ийн нэр:
   Нэр:
   Албан тушаал:
   Ажлын утас:
   Гар утас:
   Цахим шуудан:

   4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
   Эцэг/эх-ийн нэр:
   Нэр:
   Албан тушаал:
   Ажлын утас:
   Гар утас:
   Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]______________
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] ______________
ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

| | |
|---|---|
| Огноо: | **2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр** |
| Тендер шалгаруулалтын төрөл: | **Ажил** |
| Тендер шалгаруулалтын нэр: | **Оффисын барилгын засвар** |
| Тендер шалгаруулалтын дугаар: | **УБЦТС/20240101031** |
| Нийт төсөвт өртөг: | **1,329,002,823 (Нэг тэрбум гурван зуун хорин есөн сая хоёр мянга найман зуун хорин гурав) төгрөг** |
| Тендер шалгаруулалтын арга: | **Нээлттэй** |

1. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **багцтай**

   Багц-2: Ашиглалт засварын зүүн төвийн барилга засварын ажил;
   Багц-3: Баянгол ХҮТ-ийн конторын барилгын гадна тохижилт;
   Багц-4: -Баянзүрх ХҮТ-ийн оффисын засвар,
   -Баянзүрх ХҮТ-ийн хэрэглэгчид хүлээн авах хэсгийн засвар;
   Багц-5: Зуунмод ХҮТ-ийн барилгын өргөтгөл засвар;
   Багц-6:- Налайх Төвийн барилгын гадна засвар,
   -Налайх Төвийн танхим хүлээн авах хэсгийн засвар;
   Багц-7: -ӨХАЗТ-ийн монтёруудын ариун цэврийн өрөөнд засвар хийх,
   -ӨХАЗТ-ийн оффисын одоо барилгыг давхарлаж, өргөтгөн засварлах;
   Багц-8: Сүхбаатар ХҮТ-ийн танхимын засвар;
   Багц-9: Хан-Уул ХҮТ-ийн барилгын засварын ажил;

3. Тендерийг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 10 цаг 10 минутад нээнэ
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: Тийм. Тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан төсөвт өртгийн 0,5 хувьтай тэнцэх тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **Үгүй**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо,Чингисийн өргөн чөлөө-45. УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба

Утас: 342420 +157, Факс: 976-341852

Цахим хаяг: www.tender.gov.mn